

КОМПАНИЙН БОЛОН ТЕХНОЛОГИ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАНИЛЦУУЛГА

Эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн
байгууламж /жорлон/-ийн болон бохирдсон хөрсийг
цэвэршүүлэх технологийн талаар

EXCELSIOR

ЭКСЭЛСИОР ХК

〒154-0023 3-30-2 Wakabayashi Setagaya-ku, Tokyo

TEL +81-3-5431-7341 FAX +81-3-5431-7021

URL : <http://excelsior-inc.com/>

Компанийн танилцуулга.

Манай компани нь 1997 онд байгуулагдсан бөгөөд Германы Ханноверийн ИС-ийн бохирдсон хөрсийг хоргүйжүүлэх технологийн лицензийн гэрээг байгуулж, Кагошима мужийн Кавабэ хоттой хамтран диоксины бохирдолтой хөрсийг хоргүйжүүлэх туршилтыг амжилттай хийж гүйцэтгэн, 2002 оноос идэвхтэй үйл ажиллагаа явуулахаар үйлдвэрлэлийн плант байгуулав. Манай компанийн технологи нь, химийн технологиор хорт бодисыг задлан хоргүйжүүлж, ачааллыг багасгах чадалтай технологи юм. 2005 онд энэ технологийн дагуу байгалийн гамшигийн үед ашиглах ариун цэврийн байгууламжийг зохион бүтээж, асаргаа, сувилгааны салбар болон дэд бүтэц хөгжөөгүй бүс нутагт нэвтрүүлэн ашиглаж байна. Энэ оны 7-р сараас тус компанийн зөөврийн ариун цэврийн хэрэгсэл, төхөөрөмжийг Фүжи ууланд авирагчдын хэрэглээнд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн.

Тус компанийн технологийн хамрах хүрээ:

- Бохирдсон хөрсийг сайжруулах
(Диоксин, полихлорт бифенил, тос, органик бодис, хүнд металл зэрэг)
- Ариун цэврийн байгууламжийн дэд бүтэцгүй бүс нутагт эрүүл ахуйн шаардлага хангасан, таагүй үнэргүй ариун цэврийн төхөөрөмжөөр хангах



Кагошима мужийн Кавабэ хот дах диоксин
хоргүйжүүлэх байгууламж

Ариун цэврийн байгууламжийн технологи (нунтагжуулах)

【Ялгадсыг нунтагжуулах арга】

Хлорийн шохой (Quick Lime) устай урвалд ороход дулаан ялгарах зарчмыг ашиглана. Энэ үед урвал үргэлжлэх хугацааг хянах боломжтой.

Шаварлаг бодисийг хэдхэн минутын дотор доорх зураг дээрх шиг хөнгөн, нунтаг болгох хувиргах боломжтой.

Урвалд орох үед ялгарах дулаан нь 95°C хүрдэг тул ялгадасны нянг устгах боломжтой юм.



Ялгадас нь энэ зураг дээрхтэй адил хөнгөн нунтаг болно.



Иймэрхүү хялбар хутгах төхөөрөмжийг ашиглана.



【Ялгадсыг дээрхээр боловсруулсны дараа дахин ашиглах】

Хлорийн шохойг устай урвалд оруулахад үүссэн шатаасан шохойг газар тариаланд бордоо болгон ашиглах боломжтой.

Мөн барилгын материал болон сийрэг хөрстэй газрыг бэхжүүлэхэд ашиглахад тохиромжтой. Дахин ашиглалтын тухайд, тухайн нутаг дэвсгэр болон түүний оцлогт тохируулан уян хатнаар шийдвэрлэх боломжтой.



Ариун цэврийн байгууламжийн технологи (шахмал бэлдмэл)

【Хоттоирэ – relax toilet】

● Тус компанийн “Хоттоирэ—релакс тоилэт” нь шахмал бэлдмэлийг ашигладаг. Бие засахаасаа өмнө зориулалтын саванд урьдчилж бэлмэлийг хийдэг тул хэрэглэхэд амар, таатай.

● Нян устгаж, эвгүй үнэрийг дарна.

6 сараас 1 жилийн хугацааны дараа ч нян үүсэхгүй, эвгүй үнэр гарахгүй.



Хоттоирэ шахмал бэлдмэл



Ердийн бэлдмэл



Ердийн бэлдмэл нь, 1сарын дараа үнэр нь ч, ялзрал нь ч эргээд идэвхждэг.

Аль аль нь нэг сарын дараах байдал

Хэрэглэх арга

Хэрэглэхээс өмнө бэлдмэлээ уутандаа хийнэ.



Амсарыг нь сайтар бооно.



Ариун цэврийн байгууламжийн технологи (зөөврийн 00)

【Хоттоирэ】

- Зөөврийн энэхүү бүтээгдэхүүн нь олон нийтийн таашаалыг хүртдэг
- Нөмрөгтэй тул зайлшгүй шаардлагатай тохиолдолд ямар ч нөхцөлд хэрэглэх боломжтой
- Иж бүрдэл болгон савласан /ууттай/. Эмэгтэйчүүд хэрэглэхэд ч тохиромжтой.



Бодитоор ашиглагдаж байгаа жишээ

Батлан хамгаалах хүчин /хуурай замын,
тэнгисийн/, төр, засгийн байгууллагууд,
Мицүбиши-Токио банк, Мицүи Сүмитомо банк,
Токио Эрчим хүч ХК, NTT групп, Токио газ ХК
зэрэг том ААН байгууллага, сургууль зэрэг

Монголд ирсэн зорилго

Бид өөрийн компанийн технологийг нэвтрүүлснээр Монголд дараах боломжуудыг нээнэ гэж үзэж байна:

- **Ариун цэврийн байгууламжийн дэд бүтэцгүй бүс нутагт нэвтрүүлэх**
 - Нүүдэлчидийн амьралтай танилцах экотуризмын хөгжүүлэхэд зөөврийн ариун цэврийн байгууламжийг санал болгох
 - Дэд бүтэцгүй хөдөө орон нутагт нянгүйжүүлэх боломжтой, эрүүл ахуйн шаардлага хангасан, үнэргүй ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлэх
 - Боловсруулагдсаны дараа ус барих өндөр чадвартай макромолекулт полимерийг агуулдаг тул говь, цөлийг ойжуулах, ногооруулахад ашиглах бүрэн боломжтой
- **Хог хаягдал болон органик бодисоор бохирдсон бүс нутгийн хөрсийг цэвэршүүлэн сайжруулах**